

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын даргын 2023 оны 98 дугаар тушаалын 6 дугаар хавсралт

САНХҮҮ, ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ГАЗРЫН ГААЛИЙН УЛСЫН
БАЙЦААГЧ ЭНХТӨР ОВОГТОЙ САРУУЛЫН
2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
Зорилт 4. “Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх”							
1	Гаалийн байгууллагын төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, тайлагналт, хяналт тавьсан байдал	Төсвийн хэмнэлт, хувиар,	2023 онд гаалийн байгууллагын хөрөнгө оруулалтын зардалд 29,0 тэрбум төгрөг урсгал зардалд 85,0 тэрбум төгрөг батлагдсан. Урсгал батлагдсан төсвийг 11,0 тэрбум төгрөгөөр хэмнэж, тайлант хугацаанд өглөг, авлага үүсгэлгүй ажилласан.	Тайлант оны батлагдсан төсвийг оновчтой хуваарилан, зарцуулалтад хяналт тавьж, байгууллагын хэвийн үйл ажиллагааг бүрэн хангаж ажилласан байна.	Гаалийн байгууллагын 2024 оны төсвийн төслийн саналд 141,2 тэрбум төгрөгийн саналыг тусган Сангийн яаманд хүргүүлснээс урсгал үйл ажиллагааны зардлын төсөв 137,5 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ нь өмнөх онтой харьцуулахад 62%-иар буюу 52,5 тэрбум төгрөгөөр нэмэгдэж батлагдсан. Харьяа газар, хороодоос ирүүлсэн Үндсэн болон нэмэгдэл цалин, унаа хоолны	2024.01.01-2024-05-31	100%

					хөнгөлөлт, АО-с төлөх НДШ-ийн зардлууд, Төрийн тусгай албан хаагчийн сэлгэн ажилуулалт болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчийн тоотой уялдуулан үр дүнгийн урамшуулалын зардал, боомтуудын бүтээн байгуулалттай холбоотой байр ашиглалтын зардлууд, автомашинуудын урсгал засвар, тээвэр, шатахууны зардал, өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирүүлсэн албан хаагч болон нас барсан албан хаагчийн ар гэрт олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, бичиг хэрэг, улсын мэдээллийн маягт хэвлэх зардал, шуудан холбоо, багаж техник хэрэгсэл, дотоод албан томилолт, мэдээлэл технологийн үйлчилгээ, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал, тээврийн хэрэгслийн татвар, даатгалын үйлчилгээ, газрын төлбөр, хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах ажилчдын орон сууц, хилийн боомтуудын урсгал засвар, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил		
--	--	--	--	--	---	--	--

					үйлчилгээний зардлуудын 78 саналыг тооцоо, судалгааг тус тус үндэслэн төсвийн хуваарьт 6 удаагийн өөрчлөлт оруулж 23,0 тэрбум төгрөгийг хуваарилан зарцуулалтад хяналт тавин ажиллаж байна. Мөн харьяа газар, хороодын туслах үйл ажиллагааны орлогын мэдээг сар бүрийн 1-ны дотор, төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүрийн 5-ний дотор гаргуулан авч хянан, нэгтгэж Гаалийн байгууллагын нэгтгэсэн төсвийн гүйцэтгэлийн мэдээг сар бүр гаргаж Сангийн яаманд цаг хугацаанд нь хянуулан ажилласан.		
2	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Гаалийн байгууллага 2023 оны худалдан авах ажиллагааны төлөвлөгөөндөө улсын төсвийн хөрөнгө оруулалтаар он дамжин хэрэгжиж буй 3 арга хэмжээ, нээлттэй тендер	Тайлант хугацаанд төлөвлөсөн худалдан авах ажиллагааг хугацаанд нь ил тод нээлттэй зохион байгуулж, өглөг, авлага үүсгэлгүй ажилласан байна.	1.Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны 02 дугаар сарын 20-ны өдрийн А/121 дугаар тушаалаар “Гаалийн ерөнхий газрын дэргэдэх Аж ахуй, үйлчилгээний албанд шаардлагатай шатахуун худалдан авах” Үнэлгээний хороо байгуулагдан №ГЕГ/20240202001 дугаар харьцуулсан тендерийг 2024 оны 02 дугаар сарын	2024.01.01-2024-05-31	100%

			шалгаруулалтаар 3 арга хэмжээ, ерөнхий гэрээгээр 8 арга хэмжээ, урсгал зардлаас нээлттэй тендер шалгаруулалтаар 12 арга хэмжээ, харьцуулалтын аргаар 26 арга хэмжээ төлөвлөн ТБОНӨХБАҮХАТХ хуулийн дагуу хугацаанд нь хэрэгжилтийг ханган, ажил үйлчилгээ худалдан авах ажиллагааны явцад тогтмол цаг үеийн хяналтыг хэрэгжүүлэн биелэлтийг тайлагнан ажилласан.		20-ны өдөр зарлан 2024 оны 02 дугаар сарын 27-ны өдөр нээхэд материал ирүүлсэн оролцогч байгаагүй тул 2024 оны 03 дугаар сарын 05-ны өдөр цахим /www.tender.gov.mn/-аар дахин зарлан 2024 оны 03 дугаар сарын 12-ны өдөр нээлтийг зохион байгуулсан. Харьцуулсан тендерт “Шунхлайтрейдинг” ХХК, “Петростар” ХХК гэсэн 2 оролцогч материал ирүүлсэн ба Үнэлгээний хороо хянан үзэж шаардлагад нийцсэн тендерээр “Петростар” ХХК шалгарч 2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр гэрээг байгуулан худалдан авалтыг зохион байгуулсан. 2.Сангийн сайдын 2024 оны 01 дүгээр сарын 19-ний өдрийн 11 дүгээр тушаалын “Төсөл, арга хэмжээний бэлтгэл хангах /Улсын хэмжээнд/ төслийн хүрээнд санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалт”-ын IX.2.3.1.6 дахь заалтад тусгагдсан “Увс аймаг дахь гаалийн газрын гаалийн хяналт, бүрдүүлэлтийн	
--	--	--	---	--	---	--

					барилгын тохижилт, тавилга хэрэгсэл худалдан авах” нээлттэй тендерийг зохион байгуулахаар Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/170 дугаар Үнэлгээний хороог 5 хүний бүрэлдэхүүнтэй байгуулан техникийн тодорхойлолт, тендерийн жишиг бичиг баримтыг боловсруулан тендерийг 2024 оны 05 дугаар сарын 28-ны өдөр урилгыг нийтэлсэн. Тендер 2024 оны 06 дугаар сарын 18-ны өдөр нээнэ.		
3	Албан хаагчдын нийтлэг баталгаа цалин хөлс, урамшуулал, илүү цаг, тэтгэмж гэх мэт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал.	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Хилийн боомтуудад ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчийн дундаж цалин 2020 оноос 1,001,600 төгрөгөөр нэмэгдсэн байна -Өндөр насны тэтгэвэрт гарсан 27 албан хаагчдад нэг удаагийн	Төрийн албан хаагчийн нийтлэг баталгаа, төрийн жинхэнэ албан хаагчийн нэмэгдэл баталгааг хангах чиглэлээр тусламж, тэтгэмж олгох, ажиллах нөхцөл боломжийг сайжруулах, нөхөн төлбөр олгох зэрэг ажлыг хэрэгжүүлсэн байна.	1.Албан хаагчдын унаа, хоолны үнийн хөнгөлөлт нэмэгдүүлсэн: Нийтийн тээврийн тогтмол үйлчилгээ бүхий Улаанбаатар хотод ажилладаг гаалийн байгууллагын албан хаагчдын ажилдаа ирэх, буцах нийтийн тээврийн унааны зардлын хөнгөлөлт болон Гаалийн байгууллагын нийт албан хаагчдын үдийн хоолны үнийн хөнгөлөлтийг ГЕГ-ын	2024.01.01-2024-05-31	100%

			буцалтгүй тусламж болгон нийт 53,6 сая төгрөгийн тэтгэмж, Төрийн үйлчилгээний албан хаагчдад нийт 27,0 сая төгрөгийн урамшуулал, нийт төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчдын ажлын үр дүнгийн урамшуулалд 3,602.5 сая төгрөгийг тус тус олгосон байна.		даргын 2021 оны 08 дугаар сарын 04-ний өдрийн А/172 дугаар тушаалаар тогтоосноос хойш өнөөг хүртэл нэмэгдээгүй /2.5 жил/ байна. Нийслэлийн нийтийн тээврийн үйлчилгээний үнэ, тариф 2014 оны 01 дүгээр сарын 23-ны өдрөөс 500 төгрөг болсон. Зах зээлд хүнсний бараа, бүтээгдэхүүний үнэ тогтмол өсөж байгаатай холбогдуулан гаалийн байгууллагын албан хаагчдын нийтийн тээврийн унааны үнийн хөнгөлөлтийг нэмэгдүүлэх шаардлагагүй, харин үдийн хоолны үнийн хөнгөлөлтийг өнөөдрийн зах зээлийн үнэ ханштай уялдуулан нэмэгдүүлэх шаардлагатай байгааг судлан үзэж Гаалийн байгууллагын цалингийн сандаа багтаан албан хаагчдын унааны зардлын 500 төгрөгийг хэвээр үлдээж хоолны хөнгөлөлтийг 3.5 дахин буюу сард 473,0 мянган	
--	--	--	---	--	--	--

					төгрөгөөр нэмэгдүүлж олгохоор тооцооллыг хийн Захиргааны удирдлагын газарт хүргүүлж шийдвэрлүүлэн нийт батлагдсан унаа хоолны хөнгөлөлтийн зардлыг 7,8 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэн шийдвэрлэсэн. 2.Албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх: - Монгол Улсын Ерөнхий сайдын 2024 оны 01 дугаар албан даалгаварын төрийн албан хаагчдын цалинг нэмэгдүүлэх ажлын хүрээнд Төрийн тусгай болон Төрийн үйлчилгээний албан хаагчдын үндсэн цалинг 10%-иар нэмэгдүүлж, Засгийн газрын 2018 оны 382 дугаар тогтоолын 6 дугаар хавсралтаар батлагдсан “Төрийн захиргааны, үйлчилгээний болон улс төрийн албан тушаал эрхэлдэг төрийн албан хаагчид орон нутгийн нэмэгдэл олгох” журмын дагуу хөдөө орон нутагт		
--	--	--	--	--	---	--	--

					ажиллаж байгаа төрийн үйлчилгээний албан хаагчдад хөдөөгийн сум /тосгон/-д үндсэн цалингийн 40 хувиар, аймгийн төвд үндсэн цалингийн 20 хувийн нэмэгдлийг сар бүр олгохоор нийт 8,1 тэрбум төгрөгийн нэмэгдлийн тооцоо судалгааг хийж харьяа газар, хороодод санхүүжилтийг хуваарилсан. - Гаалийн байгууллагын хэмжээнд ажиллаж байгаа нийт төрийн үйлчилгээний албан хаагчдад Засгийн газрын 2019 оны 05 дугаар тогтоолын 2.2-дахь заалт 50 хүртэл хувь болж өөрчлөлт орсонтой холбоотой төрийн үйлчилгээний албан хаагчдад улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг 50 хүртэлх хувиар олгох боломжтой тооцооллыг хийж Захиргааны удирдлагын газар болон Захиргааны зөвлөлийн хурлаар танилцуулж		
--	--	--	--	--	--	--	--

					шийдвэрлүүлсэн. ТҮ1-ТҮ-7 ангиллын албан хаагчдад улиралд 150-200 мянган төгрөгийн урамшуулал нэмэгдсэн. 3. Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмж: Гаалийн ерөнхий газар болон түүний харьяа 18 байгууллагаас аймгийн төвд 2 гаалийн газар, хилийн боомтод 14 гаалийн газар, хороонд нийт 1'234 төрийн тусгай албан хаагч Үндэсний аюулгүй байдлыг хангах, улсын төсвийн орлого бүрдүүлэх тусгайлсан чиг үүргийг хэрэгжүүлэн ажиллаж байна. Хөдөө орон нутаг болон хилийн боомтод ажиллаж буй төрийн тусгай албан хаагчдын эдийн засгийн баталгааг хангах		
--	--	--	--	--	---	--	--

					үүднээс албан тушаалын сарын үндсэн цалинг 12 сартай тэнцэх хэмжээний мөнгөн урамшууллыг 5 жилд 1 удаа нийт 19,7 тэрбум төгрөг олгохоор тооцон саналыг Сангийн яаманд хүргүүлснээс 18,8 тэрбум төгрөгөөр батлагдсан. Энэ ажлын хүрээнд Гаалийн ерөнхий газрын даргын Б/240, Б/287, Б/362 дугаар тушаалуудын дагуу Улаанбаатар хотоос бусад орон нутагт тасралтгүй тав болон түүнээс дээш жил ажиллаж байгаа гаалийн улсын байцаагчид таван жил тутамд 12 сарын үндсэн цалинтай тэнцэх хэмжээний мөнгөн тэтгэмжийн 2024 оны 1-5 дугаар сард эрх нь үүссэн нийт 478 төрийн тусгай албан хаагчдад 6,6 тэрбум төгрөгийг хуваарилж олгосон байна. 4.Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагын тэтгэмж:		
--	--	--	--	--	---	--	--

					Гаалийн байгууллагаас өндөр насны тэтгэвэрч гарч буй нийт 14 албан хаагчдад 274,9 сая төгрөгийн тэтгэмжийг хуваарилж олгосон. 5.Урамшуулал: Засгийн газрын 2011 оны 345 дугаар тогтоол, 2019 оны 05 дугаар тогтоолын дагуу төрийн тусгай болон төрийн үйлчилгээний албан хаагчдын 2024 оны 1 дүгээр улирлын үр дүнгийн урамшуулалд нийт 1,6 тэрбум төгрөгийг хуваарилж олгосон.		
4.	Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт, үндсэн хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьсан байдал.	Гэрээний биелэлтийн үнэлгээгээр	Гаалийн ерөнхий газрын төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг 2023 онд 96%-р дүгнүүлсэн.	Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг хангуулах зорилгоор нийт хөрөнгийн хадгалалт, хамгаалалт, тайлан бүртгэл тооцоог сайжруулан төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлтийг	Гаалийн ерөнхий газрын Дэд даргаар байгууллагын эд хөрөнгийн ашиглалт, хамгаалалт, тайлан бүртгэл, тооцоог сайжруулах ажлуудыг хамруулсан Өмч хамгаалах байнгын зөвлөлийн 2024 оны ажлын төлөвлөгөөг батлуулсан. Уг төлөвлөгөөний дагуу дараах ажлыг хийж гүйцэтгэсэн. Үүнд: 1.Хилийн цогцолбор, конторын байр талбайг ашиглаж буй хил хяналтын	2024.01.01-2024-05-31	100%

				хангуулах чиглэлээр болон үндсэн хөрөнгө, барилга байгууламжийн ашиглалтыг сайжруулах талаар тодорхой ажил зохион байгуулсан байна.	болон бусад төрийн байгууллагуудтай байгуулах Ашиглалтын гэрээний загварыг Гаалийн ерөнхий газрын даргын 2024 оны А/11 дугаар тушаалаар батлуулан харьяа газар, хороодод хүргүүлэн нийт 11 гаалийн газар,хорооны 44 төрийн байгууллагатай гэрээг хийсэн. 2.Гаалийн байгууллагын хэмжээнд байгууллагын өмчид бүртгэлтэй газар, үл хөдлөх хөрөнгийн тооллогыг зохион байгуулж, нэгтгэлийг хийсэн. 3.“Горхи мэлхий хад” амралтын газрыг Гаалийн байгууллагын “Зайн сургалтын төв” байгуулах төслийн боловсруулах ажлын хүрээнд тус амралтын газрын байгаль орчинд нөлөөлөх байдлын нарийвчилсан үнэлгээг хийлгэхээр судлан бэлтгэл ажлыг ханган ажиллаж байна. 4.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын	
--	--	--	--	--	---	--

					burtgel.pcssp.gov.mn цахим хуудсанд 2023 оны хөрөнгийн хөдлөлтэй холбоотой мэдээ тайланг газар, хороодын хэмжээнд бүрэн оруулсан. 5.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны А-1/133 дугаар Зөвшөөрөл олгох албан бичгийн дагуу Гаалийн ерөнхий газрын даргын тушаалаар Хилийн боомтын захиргааны балансад бүртгэлтэй 141,8 сая төгрөгийн Форд маркын тусгай зориулалтын автомашиныг Эрэлч нохойн төвд шилжүүлэн авсан. 6.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 136 дугаар тогтоолын дагуу Гаалийн ерөнхий газрын даргын А/196 дугаар тушаалаар Аж ахуй, үйлчилгээний албаны балансад бүртгэлтэй үлдэх өртөгөө нөхсөн автомашиныг Дархан-Уул аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хуралд шилжүүлсэн.		
--	--	--	--	--	--	--	--

					7.Гаалийн ерөнхий газрын зохион байгуулалтын бүтэц, орон тоо шинэчлэн батлагдсантай холбогдуулан Ханги дахь гаалийн газарт нийт 45,5 сая төгрөгийн балансын үнэ бүхий компьютер, тоног төхөөрөмжийг Гаалийн ерөнхий газрын даргын А/197 дугаар тушаалаар хуваарилсан. 8.Гаалийн ерөнхий газрын Санхүү, хөрөнгө оруулалтын газраас харьяа газар, хороодод нийт 646,6 сая төгрөгийн тоног төхөөрөмжийг Гаалийн ерөнхий газрын даргын А/198, А/199, А/320 дугаар тушаалаар хуваарилсан. 9.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 142 дугаар тогтоол, Эрчим хүчний яамны 2024 оны 5/845 дугаар албан бичгийн дагуу Эрчим хүчний яамны балансаас Чингис хаан олон улсын нисэх буудал дахь гаалийн газрын балансад 494,5 сая төгрөгийн рентген тоног төхөөрөмжийг Гаалийн		
--	--	--	--	--	--	--	--

					ерөнхий газрын даргын 2024 оны А/207 дугаар тушаалаар бүртгэлд тусгасан. 10.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны 135 дугаар тогтоолын дагуу Гаалийн ерөнхий газрын даргын А/208 тушаалаар Баян-Өлгий аймаг дахь гаалийн газрын нийт 397м2 газар эзэмших эрхийг данснаас хассан. 11.Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2024 оны “Хөрөнгө солилцон бүртгэх тухай” 206 дугаар тогтоолын дагуу Гаалийн ерөнхий газрын даргын А/342, А/343 тушаалуудаар Орхон аймаг дахь гаалийн газрын балансд бүртгэлтэй 2 өрөө байрыг иргэн П.Энхбатын өмчлөлийн байраар солиж зохих журмын дагуу бүртгэлд тусгасан.		
5	Төсөв, санхүүгийн шилэн дансны мэдээлэл байршуулах, хяналт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Шилэн дансны мэдээллийг хуулийн хугацаанд нь шилэн дансны	Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилтийг бүрэн ханган ажилласан байна.	ЗГ-ын 2009 оны 143-р тогтоол Ил тод байдлын шалгуур үзүүлэлтийн төсвийн ил тод байдал болон Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр	2024.01.01-2024-05-31	100%

			цахим хуудсанд 100%, иж бүрэн байршуулсан бөгөөд хугацаа хоцроосон болон байршуулаагүй мэдээлэл өмнөх онд байхгүй болно.		бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны ил тод байдлын шалгуур үзүүлэлтийг дараах байдлаар ханган ажиллаа. Мэдээллийн ил тод байдал ба мэдээлэл авах эрхийн тухай хуулийн дагуу нууцад хамааруулснаас бусад мэдээллийг Гаалийн байгууллагын www.customs.gov.mn цахим хуудасны Ил тод байдалын цэс болон шилэн дансны цахим хуудас санхүүгийн мэдээ, мэдээллийг хуулийн хугацаанд нь нийтэд ил тод байхаар байршуулсан болно. 1. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл, хэтрэлт хэмнэлтийн шалтгаан тайлбарын хамт сар бүр 5 мэдээлэл 2. Төсвийн байгууллагын батлагдсан төсөв, гүйцэтгэл – Хөтөлбөр, зориулалт сар бүр 5 мэдээлэл 3. Байгууллагын батлагдсан төсөв жилд нэг удаа 2024.01.10-нд 4. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий	
--	--	--	--	--	--	--

					зарлагын мөнгөн гүйлгээ – тухай бүрт нь 32 мэдээлэл 5. Цалингийн зардлаас бусад таван сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий орлогын мөнгөн гүйлгээ – тухай бүрт нь 62 мэдээлэл 6. Тухайн жилийн төсөвт орсон нэмэлт өөрчлөлт тухай бүрт нь 6 мэдээлэл 7. 5 сая төгрөгөөс дээш үнийн дүн бүхий худалдан авсан бараа, ажил, үйлчилгээний нэр, санхүүжилтийн хэмжээ, нийлүүлэгчийн нэр, хаяг – тухай бүрт нь 39 мэдээлэл 8. Бонд, зээл, өрийн бичиг, баталгаа, түүнтэй адилтгах санхүүгийн бусад хэрэгсэл, төр хувийн хэвшийн түншлэлийн гэрээ, концесс, төсөв, өмч, хөрөнгө, мөнгө зарцуулах, өр, өвлөгө үүсгэсэн аливаа шийдвэр – тухай бүрт нь 47 мэдээлэл 9. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт, гүйцэтгэл – сар бүр 5 удаагийн мэдээлэл		
--	--	--	--	--	--	--	--

					10. Худалдан авах ажиллагааны төлөвлөгөө – жил бүр 2024.01.10-нд 11. Хөрөнгийн зардал, хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл, концессын зүйлийн жагсаалт – жил бүр 2024.01.10-нд 12. Хөрөнгийн болон урсгал зардалд тусгагдсан арга хэмжээний тендерийн ерөнхий мэдээлэл – тухай бүрт нь 4 мэдээлэл 13. Худалдан авах ажиллагаанд хийсэн аудитын тайлан, дүгнэлт болон бусад хяналт шалгалтын дүн – Тухай бүрт нь 5 удаагийн мэдээлэл Хугацаа хоцроосон болон оруулаагүй мэдээлэл байхгүй.		
6	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	Төсвийн хэмнэлт, хувиар, үүссэн өглөг, авлага, төгрөгөөр, гэрээний биелэлтийн үнэлгээгээр	Суурь үнэлгээ:4	Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд ГЕГ-ын даргын 2024 оны А/190 дүгээр тушаалын хавсралтад заасан бодлогын баримт бичгийн хэрэгжилтийг	Үндсэн болон нэмэгдэл цалин, унаа хоолны хөнгөлөлт, АО-с төлөх НДШ-ийн зардлууд, Төрийн тусгай албан хаагчийн сэлгэн ажилуулалт болон сахилгын шийтгэл ногдуулсан албан хаагчийн тоотой уялдуулан үр дүнгийн урамшуулалын зардал, боомтуудын бүтээн	2024.01.01-2024-05-31	100%

				тайлагнан ажилласан байна.	байгуулалттай холбоотой байр ашиглалтын зардлууд, автомашинуудын урсгал засвар, тээвэр, шатахууны зардал, өндөр насны тэтгэвэр тогтоолгох хүсэлт ирүүлсэн албан хаагч болон нас барсан албан хаагчийн ар гэрт олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн зардал, бичиг хэрэг, улсын мэдээллийн маягт хэвлэх зардал, шуудан холбоо, багаж техник хэрэгсэл, дотоод албан томилолт, мэдээлэл технологийн үйлчилгээ, аудит баталгаажуулалт, зэрэглэл тогтоох зардал, тээврийн хэрэгслийн татвар, даатгалын үйлчилгээ, газрын төлбөр, хилийн боомтуудын хэвийн үйл ажиллагааг хангах ажилчдын орон сууц, хилийн боомтуудын урсгал засвар, гэрээгээр гүйцэтгүүлэх ажил үйлчилгээний зардлуудын 78 саналыг тооцоо, судалгааг тус тус үндэслэн нийт 23,0 тэрбум төгрөгийг төсвийн хуваарьт 6 удаагийн өөрчлөлт оруулж харьяа газар, хороодод хуваарилан зарцуулалтад		
--	--	--	--	-------------------------------	--	--	--

					хяналт тавин ажиллаж байна. Гаалийн байгууллага нь 2024 оны 05 дугаар сарын 31-ний байдлаар 19,5 тэрбум төгрөгийн хэмнэлттэй ажилласан байна.		
7	Хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Өмнөх оны үнэлгээ:4	Нэгжийн чиг үүрэгт хамааралтай болон бусад холбогдох хууль тогтоомж, эрх зүйн актыг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	-Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Шилэн дансны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Гаалийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль, Төсвийн тухай хууль, болон хуульд нийцүүлэн гаргасан алиаа эрх зүйн актын хэрэгжилтийг хангаж ажилласан. -Гаалийн байгууллагын урсгал үйл ажиллагааны төсвийн сар улирлын хуваарь болон 1-5 сарын төсвийн гүйцэтгэлийн мэдээг гарган ажилласан. -Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах,	2024.01.01-2024-05-31	100%

					ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хуулийн 23.3-т заасан хугацаандаа 2023 оны хөрөнгө, орлогын мэдүүлгийг ХАСХОМ-ын системд мэдүүлж, байгууллагын ЭБАТ-аар баталгаажуулсан.		
8	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	2024 оноос хэрэгжиж эхэлж буй шалгуур	Өөрийн нэгжийн чиг үүргийн хүрээнд эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлж ажилласан байна.	-Албан хаагчдын нийгмийн баталгааг хангах зорилгоор хилийн боомтоос гаалийн хяналтын бүс рүү зөөвөрлөх, алслагдмал хилийн боомтуудаас ар гэртээ хүрэх замдаа зам тээврийн осолд өртөх, гэмтэж бэртэх тохиолдлууд их байдаг тул аюулгүй байдлыг нь бүрэн хангаж чадахгүй байгаад дүн шинжилгээ хийж, нийт 2400 албан хаагчдыг 2024 онд ГЭНЭТИЙН ОСЛЫН ДААТГАЛД бүрэн хамруулах зардал болох 100,0 сая төгрөгийг төсөвт тусгасан. -Сүүлийн жилүүдэд боомтын шинэчлэлийн хүрээнд хилийн гаалийн хяналт шалгалтын /ухаалаг гарц, телехяналтын систем, рентген, хар тамхи/ болон лабораторийн тоног төхөөрөмжүүд шинэчлэгдэн	2024.01.01-2024-05-31	100%

					орчин үеийн тоног төхөөрөмжийг ашиглаж байгаа хэдий ч байгалийн болон давагдашгүй хүчин зүйлсийн нөлөөгөөр гэмтэх, шатах, эвдрэх нөхцөл байнга үүсч байгаа тул ЭД ХӨРӨНГИЙН ДААТГАЛД хамруулах зардал болох 300,0 сая төгрөгийг төсөвт тусгасан.		
9	Үүрэг даалгавар, зөвлөмжийн биелэлт	Хэрэгжилт, гүйцэтгэлээр	Өнгөрсөн оны үнэлгээ: 4.2	Нэгжийн чиг үүргийн хүрээнд өгөгдсөн үүрэг даалгавар, зөвлөмжийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	-Тайлант хугацаанд нийт 31 албан бичиг боловсруулан илгээж, ГЕГ-ын ЗББНДБ-аас ирсэн явсан дотоод зурвасууд мөн 174 албан бичгийг шийдвэрлэн хариуг хүргүүлсэн байна. -Санхүү, хөрөнгө оруулалтын газраас Гаалийн ерөнхий газрын даргын 2024 онд харьяа газар, хороодод өгөх албан даалгаварын саналыг хүргүүлсэн. - Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу харьяа газар, хороодоос шаардлагатай төсвийн саналыг авч нэгтгэсэн. -Гаалийн хорио цээрийн программын хөгжүүлэлтийн	2024.01.01-2024-05-31	100%

					ажлын хэсэгт гишүүнээр ажиллан өөрийн нэгжийн чиг үүрэгт харьяалагдах программын хөгжүүлэлтийн саналуудаа тусгасан. - Удирдлагаас өгсөн үүрэг даалгаваруудыг тухай бүр хэрэгжүүлэн ажилласан.		
10	Ажлын цаг ашиглалт	Хэрэгжилт, хувиар	Өмнөх оны үнэлгээ: 5	Нэгжийн албан хаагчдын ажлын цаг ашиглалт 100% байна.	Ажлын цаг ашиглалт 100%. Тайлант хугацаанд өвчтэй, чөлөөтэй, тасалсан цаг байхгүй.	2024.01.01-2024-05-31	100%
11	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	Хэрэгжилт, биелэлтээр	Өмнөх оны үнэлгээ: 9	Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгагдсан өөрийн нэгжид хамааралтай ажлуудыг төлөвлөгөөнд заасан хугацаанд бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.	-Сангийн сайдын 2018 оны 253 дугаар тушаалын дагуу улсын хилээр нэвтрүүлэх тээврийн хэрэгсэл, бараа бүтээгдэхүүнд хийх халдваргүйжүүлэлтийн жишиг үнээр харьяа гаалийн газар, хороодод орж буй орлогыг Гаалийн ерөнхий газрын улсын төсвийн дансанд төвлөрдөг байхаар зохион байгуулалтыг хийсэн. -Гаалийн байгууллагын 2024 оны Хөгжлийн бэрхшээлтэй иргэний эрхийг хангах үйл ажиллагааны төлөвлөгөөний дагуу тайлант хугацаанд нийт 16 харьяа гаалийн газар, хороодоос 216,0 сая төгрөгийн хөгжлийн бэрхшээлтэй иргэнд	2024.01.01-2024-05-31	100%

					зориулсан зорчих зам, тоног хэрэгсэл болон бусад шаардлагатай зардлын төсвийн төслийг авч Гаалийн байгууллагын 2025 оны урсгал үйл ажиллагааны төсөвт тусгуулахаар нэгтгэсэн.ба 2024 онд санхүүжүүлэх боломжтой зардлуудыг үе шаттайгаар санхүүжүүлэхээр төлөвлөж ажиллаж байна.		
--	--	--	--	--	--	--	--

Хоёр. Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин				
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн дууссан хугацаа	Биелэлтийн хувь
	1	2	3	4	5	6	7
1	Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд богино хугацааны зорилтот сургалтад хамрагдах			Танхимаар болон цахим хэлбэрээр сургалтад хамрагдсан байна.	1.Дэлхийн гаалийн байгууллагаас зохион байгуулсан “Гарал үүсэл” үндэсний сургалтад 2024 оны 03.25-03.29 хооронд хамрагдсан. 2.Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Удирдлагын академи, Засгийн газрын Хэрэг эрхлэх газраас зохион байгуулсан “Төрийн албан хаагчийн хөгжил,	2024.01.01- 2024-05-31	100%

					хамгаалал” хэлэлцүүлэгт хамрагдсан. 3. Азийн хөгжлийн банкны техник туслалцааны хүрээнд зохион байгуулсан FIDIC буюу олон улсын гэрээний сургалтад хамрагдсан. 4.Байгууллагаас зохион байгуулсан мэдээллийн цагт тухай бүр хамрагдсан.		
2	Бие даан суралцах			Танхимаар болон цахим хэлбэрээр сургалтад хамрагдсан байна.	1.Хаан банктай хамтын ажиллагааны хүрээнд +16,000 сургалтын сантай дэлхийд тэргүүлдэг цахим сургалтын систем бүхий Linked in Learning хөтөлбөрт суралцах эрхийг авсан. 2. Их Засаг Олон улсын Их Сургуулийн Эрх зүйн магистр зэрэгт суралцаж байна.	2024.01.01-2024-05-31	100%

ТАЙЛАН ГАРГАСАН:

СХОГ-ЫН ГУБ
(Албан тушаал)

.....
(Нэр, гарын үсэг)

2024 оны 06 сарын 10
(Огноо)

Засгийн газрын Хэрэг эрхлэх газрын
даргын 2023 оны 98 дугаар тушаалын
6 дугаар хавсралт

ГААЛИЙН УЛСЫН БАЙЦААГЧ ЭНХТӨР ОВОГТОЙ САНУУЛЫН
2024 ОНЫ ЭХНИЙ ХАГАС ЖИЛИЙН АЖЛЫН ГҮЙЦЭТГЭЛ, ҮР ДҮН,
МЭРГЭШЛИЙН ТҮВШИНГ ҮНЭЛЭХ ҮНЭЛГЭЭНИЙ ХУУДАС
(ГҮЙЦЭТГЭХ АЛБАН ТУШААЛТАН)

Байгууллагын нэр: Гаалийн ерөнхий газар

Нэгжийн нэр: Санхүү, хөрөнгө оруулалтын газар

1. ГҮЙЦЭТГЭЛИЙН ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний гүйцэтгэлд өгсөн оноо	Төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэсэн байдал	Нийлбэр оноо	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
	1	2	3	4	5
	Оноо	60 хүртэл	10 хүртэл	70 хүртэл	
Зорилт 1. "Гаалийн байгууллагын дэд бүтэц, чадавхыг бэхжүүлэх"-ийг хэрэгжүүлсэн арга хэмжээний биелэлт					
1.	Төсөв, хөрөнгө оруулалтын төлөвлөлт, зарцуулалт, хяналт тавьсан байдал	55	10	65	
2.	Бараа, ажил, үйлчилгээ худалдан авах ажиллагааны зохион байгуулалт, үр дүн	55	8	63	
3.	Албан хаагчдын нийтлэг баталгаа цалин хөлс, урамшуулал, илүү цаг, тэтгэмж гэх мэт ажиллах нөхцөл боломжийг бүрдүүлсэн байдал	55	10	65	
4.	Төрийн өмчийг эзэмшүүлэх гэрээний биелэлт, үндсэн хөрөнгийн бүртгэл, тэдгээрийн эзэмшил, ашиглалтад хяналт тавьсан байдал.	55	8	63	
5.	Төсөв, санхүүгийн шилэн дансны мэдээлэл байршуулах, хяналт	55	10	65	
6.	Бодлогын баримт бичгийн зорилт, арга хэмжээний хэрэгжилт	55	10	65	
7.	Хууль, тогтоомж, эрх зүйн актын хэрэгжилт	56	10	66	

8.	Нэгжийн эрсдлийн удирдлагыг хэрэгжүүлсэн байдал	55	10	65	
9.	Үүрэг даалгаврын биелэлт	55	10	65	
10.	Ажлын цаг ашиглалт	60	10	70	
11.	Үндсэн шалгуурт тусгагдаагүй бусад чиг үүргийн хэрэгжилт	55	10	65	
Дундаж оноо:				65	65

2. МЭДЛЭГ, УР ЧАДВАРАА ДЭЭШЛҮҮЛЭХ ЗОРИЛТ, АРГА ХЭМЖЭЭНИЙ БИЕЛЭЛТ

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Арга хэмжээний биелэлтийг хувь	Нийт (15 хүртэл оноогоор)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	1	2	3	4
1.	Хариуцсан ажлын чиг үүргийн хүрээнд богино хугацааны зорилтот сургалтад хамрагдах	100	15	
2.	Бие даан суралцах	100	15	
Дундаж оноо:				15

3. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (НЭГЖИЙН ДАРГЫН ҮНЭЛГЭЭ)

Д/д	Үзүүлэлт	Нэгжийн даргын үнэлгээ (0-7)	Үнэлгээний багийн хянан баталгаажуулж, дахин үнэлсэн оноо
1.	1	2	3
1.	Хандлага, ёс зүй	6	
2.	Асуудал шийдвэрлэх	5	
3.	Хариуцлагатай байдал	6	
4.	Дүн шинжилгээ хийх	5	
5.	Ажлын цаг ашиглалт	6	
Ур чадварын үзүүлэлт (ажлын онцлогоос хамаарсан)			
6	Мэргэжлийн ур чадвар 1.	6	
Дундаж оноо:		5.6	5,6

4. ХАНДЛАГА, ЁС ЗҮЙ, УР ЧАДВАРЫН ҮНЭЛГЭЭ (ХАМТ ОЛНЫ ҮНЭЛГЭЭ)

Д/д	Хандлага, ёс зүй, ур чадвар	Хамт олны үнэлгээ (0-8)
	1	2


1.	Хандлага, ёс зүй	7
2.	Багаар ажиллах	7
3.	Харилцаа	7
Дундаж оноо: 7		

5. ГҮЙЦЭТГЭЛИЙН ҮНЭЛГЭЭ

Д/д	Үнэлгээний үзүүлэлт	Үзүүлэлт тус бүрийн оноо
1.	Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт (Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт орно)	65
2.	Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний биелэлт	15
3.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Нэгжийн даргын үнэлгээ)	5.6
4.	Хандлага, ёс зүй, ур чадварын үнэлгээ (Хамт олны үнэлгээ)	7
5.	Үнэлгээний оноонд орсон өөрчлөлт (Аргачлалын 6 дугаар хэсэгт заасан холбогдох заалтыг бичих)	
Нийт оноо =		92.6
(Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний оноо + Мэдлэг, ур чадвараа дээшлүүлэх зорилт, арга хэмжээний оноо + Хандлага, ёс зүй, ур чадварын оноо (Нэгжийн даргын болон хамт олны үнэлгээ)) - Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу хассан оноо + Аргачлалын 6 дугаар хэсгийн холбогдох заалтын дагуу нэмсэн оноо		

Үнэлгээ өгсөн:

Санхүү, хөрөнгө оруулалтын газрын
албан үүргийг түр орлон гүйцэтгэгч
(албан тушаал)

Нэгжийн дарга


..... /Д.Долгорсурэн/
(албан хаагчийн нэр)

..... 2024.06.10 (огноо)

Үнэлгээтэй танилцаж, зөвшөөрсөн:

Төрийн жинхэнэ албан хаагч:

Гаалийн улсын байцаагч
(албан тушаал)

.....
(гарын үсэг)

/Э.Саруул/
(албан хаагчийн нэр)

..... 2024.06.10 (огноо)

Үнэлгээг хянасан :

Үнэлгээний багийг төлөөлж ахлагч:

Дэд даргын албан үүргийг
түр орлон гүйцэтгэгч

(албан тушаал)

.....

(гарын үсэг)

ЛГ.Энхтайван/

2024.07.26. (огноо)

Үнэлгээний багийн нарийн бичгийн дарга:

Хүний нөөцийн хэлтсийн
даргын албан үүргийг түр
орлон гүйцэтгэгч

(албан тушаал)

.....

ЛЖ.Баясгалан/

2024.07.26. (огноо)

Үнэлгээг баталгаажуулсан: Төсвийн шууд захирагч

Гаалийн ерөнхий газрын дарга

(албан тушаал)

..... /Р.Отгонжаргал/

(гарын үсэг)

2024.07.26. (огноо)

